



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/А1

Булган сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6, Ахмад настны тухай хуулийн 12.1, 12.4, 12.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үзэсгэлэн болгогч хэмээх Харагчин туулай жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга)
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын
дарга)

Г.Алдармөнх (Соёл, урлагийн газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ж.Халиун (Хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Булган сумын багийн Засаг дарга нар (1,2,3,4,5,6-р баг)
Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

2. Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг чанартай, хурдан шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА


Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010011

Аймгийн Засаг даргын 20... оны
 дугаар сарын ...-ний өдрийн дугаар
 захирамжийн хавсралт



АХМАД НАСТНУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
 БАЙГУУЛАХ АЖЛЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5
Нэг. Хэвлэл, мэдээллийн арга хэмжээ				
1.	Аймгийн засаг даргын мэндчилгээ бэлтгэн иргэд олон нийтэд хүргэх	02/03	Б.Мягмарсүрэн (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)	Г.Алтанцэцэг (Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
2.	Удирдамж, постерийн эх бэлтгэл хийх, оны онцлох 10 үйл явдлын видео шторжийг ледээр гаргах	02/15	Б.Мягмарсүрэн (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)	Ж.Халиун (Хөгжимт жүжгийн театрын дарга)
3.	Сандал, ширээ зөөж байршуулах	02/14	П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга)	Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
4.	Тайз засах, лед дэлгэц байрлуулах, урлагийн арга хэмжээг бэлтгэх	02/13-14	Ж.Халиун (Хөгжимт жүжгийн театрын дарга)	Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
5.	1000 ахмад, 90+ ахмадын судалгааг гаргах, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх гарын бэлэг боож бэлдэх, тавгийн ширээ бэлтгэх, ахмадуудад үйлчлэх	02/03	Н.Батжаргал Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)	П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга), Багийн засаг дарга нар (1,2,3,4,5,6-р баг)
6.	Ном хурах үйл ажиллагааг бэлтгэх	02/15	Ш.Мөнхжаргал (Дашчойнхорлин хийдийн хамба лам)	Б.Мягмарсүрэн (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
7.	1093 ширхэг календарь бэлтгэх	02/13	Б.Мягмарсүрэн (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)	Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
8.	1093 ширхэг цаасан хайрцаг бэлтгэх	02/13	Б.Мягмарсүрэн (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)	Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга) П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга), Багийн засаг дарга нар (1,2,3,4,5,6-р баг)